МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр,
Утас: 31 06 12, 7600 3333-1126, Факс: (976-11) 32 29 04,
И-мэйл: info@mcud.gov.mn, Вэбсайт: www.mcud.gov.mn

2021.01.14 № 3/180

танай ____________-ны №____________-т

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАРТ

Барилга, хот байгуулалтын яамны Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт болон авлигын эсрэг үйл ажиллагааны 2020 оны жилийн эцсийн тайланг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт...38... хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.МАГНАЙСҮРЭН

151060055

# БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2021.01.15

ХЭЛЭЛЦСЭН НЬ: УИХ-ын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны 51 дүгээр тогтоолоор батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилт, Авлигын эсрэг үйл ажиллагааны 2020 оны жилийн эцсийн тайланг хэлэлцсэн тухай.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр", Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Барилга, хот байгуулалтын Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2020 оны жилийн эцсийн байдлаар үнэлгээ хийж тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх;
2. Тайланд тусгагдсан хугацаа болоогүй, үнэлэх боломжгүй, бүрэн хангалттай үнэлгээнд хүрч чадаагүй арга хэмжээг яамны 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллахыг холбогдох газрын дарга нарт тус тус үүрэг болгов.

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

# БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ БОЛОН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

**2021.01.15**

**Нэг. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд:**

| Д/д | Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа | Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжилт | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| **Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр** | | | | | | |
| 1 | 4.1.1.1.төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх | Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСХУМ/-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох | Тайлант хугацаанд Барилга, хот байгуулалтын яамны 8 сул орон тоо, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын 6 сул орон тоонд сонгон шалгаруулалт явуулах ажлыг зохион байгуулж, салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлснээр томилуулах саналыг томилох эрх бүхий этгээдэд хүргүүлж, улмаар томилогдох этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3, 22.1.5 дахь заалт хангаж байгаа тухай баримтыг холбогдох байгууллагуудаас нь авч тус бүрийн хувийн хэрэгт нь хавсаргахыг анхааруулж, энэ талаарх биелэлтэд хяналт тавьж ажилласан.<br><br>Тус яаманд томилогдсон албан хаагчдад албан тушаалын тодорхойлолтыг танилцуулж, гарын үсэг зуруулахын зэрэгцээ, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг гаргах, ял шийтгэлгүйн тодорхойлолтыг ирүүлэх, гүйцэтгэлийн | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | төлөвлөгөө боловсруулах, зарим албан хаагчдад ажил хүлээлцэх зэрэг хугацаатай мэдэгдлийг хүргүүлж ажилласан. Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСХУМ/-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгож яамны https://mcud.gov.mn/a/622 цахим хаягийн ил тод/Авлигын эсрэг/Урьдчилсан мэдүүлэг хянасан гэсэн талбарт байршуулж хэвшсэн.<br><br>Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн Гадаад хамтын ажиллагаа хариуцсан шинжээчээр Б.Анх-Оргилыг, Бодлого төлөвлөлтийн газрын Салбарын норм, нормативын бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээчийн орон тоонд Б.Гандолгорыг шилжүүлэн томилохоор, НААБХЗГ-ын усны барилга, байгууламжийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтний сул орон тоонд М.Жаргалсайханыг түр, Гадаад хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтний сул орон тоонд Б. Энх-Амгаланг, Хот байгуулалт газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтний орон тоонд Байжаны Нурбекийг томилохоор тус тус нэр дэвшүүлсэн бөгөөд эдгээр албан хаагчдын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар АТГ-т хүргүүлж хариуг ирмэгц ТЗУГ-ын хүний нөөц хариуцсан ахлам мэргэжилтэнд хувилж өгсөн. Мөн томилогдсон Х.Ерхулан, Б.Анх-Оргил нарын ХАСХОМ-ыг хугацаанд нь авч хянан баталгаажуулсан.<br><br>Шинээр болон шилжин томилогдсон Ням-Очир, Э.Оюунчимэг, С.Оюунжаргал,Б.Нурбек, Б.Гандолгор, Б.Энх-Амгалан нарын ХАСХОМ-ыг хугацаанд нь авч хянан баталгаажуулсан. | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Мөн “Хариуцлага тооцож, хуулийн хэрэгжилтийг хангах ажиллах тухай” АТГ-аас ирүүлсэн 01/3929 албан бичгийн мөрөөр тус яамны Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Б.Алтайбаатар, Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн зохицуулагч Т.Болорчулуун, Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч О.Энхтуяа нарт Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулж, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээг тооцуулахаар ТНБД-ын тушаалын төслийг боловсруулж, арга хэмжээг тооцуулав. Дээрх албан тушаалтанд арга хэмжээ авсан талаар болон хуулийн хэрэгжилтийг хангах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай 03/1297 албан бичгийг АТГ-т хүргүүлсэн.<br><br>Засгийн газрын 2020 оны 104 дүгээр тогтоолын дагуу тус яамны бүтцийн нэгжийг шинэчлэн батлаж нийт хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталсан бөгөөд энэ дагуу албан тушаалын чиг үүрэг нь солигдсон болон шинээр томилогдсон нийт 55 албан хаагчдын ХАСХУМ-ыг хянуулахаар АТГ-д хүргүүлж, томилогдсон 55 албан хаагчийн ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд нь бүрэн гаргуулж хянаж баталгаажуулсан.<br><br>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан 196 мэдэгдлийг хүлээн авч бүртгэв. Яамны цахим хуудсанд 2020 онд шинээр | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ хянасан АТГ-ын албан бичгийг байршуулсан.<br><br>**ХҮРСЭН ҮР ДҮН:** Дүгнэлтийг нээлттэй ил тод болгох ажил хэвшсэн. | | | |
| | | Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох | ТНбД-ын 2019 оны Б/85 дугаар тушаалаар яамны албан тушаал, албан тушаалын чиг үүргийг шинэчлэн баталж, улмаар Б/100-р тушаал болон холбогдох бусад тушаалаар албан хаагчдыг шинэчлэн баталсан орон тоонд томилсон, зарим албан хаагч өөр газар, хэлтэст шилжсэнтэй холбоотой нийт 65 албан хаагчийн хувийн хэргийн нэрийг өөрчлөн хэвлүүлж өөрчилсөн нэрээр хувийн хэргийг цэгцэлсэн.<br><br>- Хүний нөөцийн програмд хүний нөөцийн хөдөлгөөн, шинэчилсэн цалин, хоол, унаа, зэрэг дэвийн нэмэгдлийг бүрэн бүртгэж оруулсан.<br><br>- Төрийн албаны зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 2020 оны анхдугаар хуралдаанаар тус зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлж улмаар Салбар зөвлөлийн даргын 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.<br><br>Хүний нөөцийн ил тод байдалтай холбоотой мэдээллийг яамны цахим хуудасны https://mcud.gov.mn/as/tasz-д байршуулдаг. Мөн шилэн дансны https://shilendans.gov.mn/ системд байршуулахаас гадна Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу цахимаар олон нийтэд мэдээлж, сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны Төв зөвлөлд хүргүүлэн ажилладаг.Ажлын байрны зарыг нээлттэйгээр https://mcud.gov.mn/as/ajliinzar байршуулдаг. | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | **ХҮРСЭН ҮР ДҮН:** Нөөцийн жагсаалт, бүртгэл ил тод, нээлттэй болсон. | | | |
| 2 | 4.1.1.2.нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтны мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх | Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх | Засгийн газрын 2020 оны 104 дүгээр тогтоолоор Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлагдагдаж 7 газар, 7 хэлтэстэйгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэх болсонтой холбогдуулж яамны бүтцийн нэгжийн орон тоо, чиг үүрэг, албан тушаал, албан тушаалын чиг үүргийг шинэчлэн боловсруулж Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 127 дугаар тушаалаар 7 газар, 7 хэлтэс, 78 орон тооны чиг үүргийг шинэчлэн батлуулсан.<br><br>Төрийн албаны зөвлөлийн хурлаар дэмжиж зөвшөөрөл олгосны дагуу Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 130 дугаар тушаалаар төрийн захиргааны 65 албан тушаалын тодорхойлолтыг баталж тусгай шаардлага хангасан албан хаагчдыг томилсон 131 дүгээр, үүргийг түр хариуцуулахаар 132 дугаар тушаалыг гаргаж албан тушаалд томилсон.<br><br>Бүтэц орон тооны өөрчлөлт гарсан, сэлгэн болон шилжүүлэн томилсонтой холбоотойгоор гарсан сул, эзгүй орон тооны мэдээллийг тухай бүр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.<br><br>Мөн салбар зөвлөлийн тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн гаргасан судалгаа, дүгнэлтийг үндэслэн 12 албан хаагчид ажилласан жилийн нэмэгдлийг шинэчлэн тогтоосон. Түүнчлэн шинэчлэн батлагдсан Төрийн албаны тухай хуулийн 77 дугаар зүйлд төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2020 оны 01 | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасантай холбоотой тус яамны үйлчилгээний албан тушаалд ажиллаж байгаа 4 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг дээрх тушаалаар хамтатган шийдвэрлүүлсэн.<br><br>Салбар зөвлөлийн 2020.01.15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын дагуу яамны 1 **албан хаагчид** Тэргүүн түшмэлийн дэд зэрэг, 2 албан хаагчид эрхэлсэн түшмэлийн гутгаар зэрэг тус тус олгуулах саналаа салбар зөвлөлийн 2020.01.22-ны өдрийн 02 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлж шийдвэрлүүлсэн.<br><br>**ХҮРСЭН ҮР ДҮН:** Төрийн албаны тухай хуульд заасны дагуу шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. | | | |
| 3 | 4.1.1.9.төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулах | Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцэд холбогдох | Дотоод удирдлагын "Эйбл" системийн "Албан бичиг" цэсэнд "бичиг төлөвлөлт" цэс нэмэж ажиллагаанд оруулсан. Гар утсанд апликейшн программ суулгаж үйл ажиллагаанд оруулах бэлтгэлийг хангасан. Домэйн нэрний цэсэнд БХБЯ-ны домэйнийг оруулах шинэчлэл хийгдэж байна.<br><br>Эйбл программын утасны application playstore-д орсон хөгжүүлэлтийг хийж, тоон гарын үсгийн модуль нэвтэрсэн, "гүйцэтгэлийн төлөвлөгөө" модуль шинээр нэмж ашиглах боломжтой болсон. Тоон гарын үсэг тээгч төхөөрөмжид гэрчилгээг суулгах ажлын бэлтгэл ажлыг хангаан | 70% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | ажилласан. 71 албан хаагчийн тоон гарын үсэг эзэмших өргөдөл, гэрээ бүхий цаасан материалыг бүрдүүлж "Үндэсний дата төв" УТҮГ-т хүргүүлсэн. Тоон гарын үсэг хэрэглэгчдийг бүртгэх Монгол улсын нийтийн түлхүүрийн дэд бүтцийн Бүртгэлийн нэгжийн систем (https://ra.datacenter.gov.mn)-д яамны албан хаагчид нийт 71 тоон гарын үсгийн гэрчилгээний бүртгэл хийсэн, тээгч төхөөрөмжид гэрчилгээг суулгасан. Бүртгэлийн нэгжийн систем (https://ra.datacenter.gov.mn)-д 71 албан хаагчдын тоон гарын үсэг хэрэглэх хүсэлтийг хийсэн. Үндэсний дата төвийн тоон гарын үсгийн бүртгэл эрхэлсэн мэргэжилтэнд өөрийн байгууллагын албан хаагчдын тоон гарын үсэг ашиглах өргөдөл, тоон гарын үсэг ашиглах гэрээ, тоон гарын үсэг суулгах төхөөрөмж хүлээлгэн өгсөн. Тоон гарын үсэг тээгч төхөөрөмжид суулгах ажил Үндэсний дата төвд хийгдэж байна. "Тоон гарын үсгийн хэрэглээ" сэдэвтэй сургалтыг яамны албан хаагчдын дунд зохион байгуулсан.<br><br>Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын хувьд Үндэсний Дата төвөөс олголт хийгдсэн тохиолдол бүрд байгууллагын болон 21 аймгийн ГХБХБГ-ын тоон гэрчилгээ ашиглах шаардлагатай албан хаагчдад хүлээлгэн өгч ажилласан байна.<br><br>Мөн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.<br><br>-Тоон гарын үсгийг байгууллагын дотоод удирдлагын Эйбл системийн бичиг төлөвлөлтийн хэсэгт нэвтрүүлсэн. Ирсэн албан бичигт цохолт хийх, шилжүүлэхэд тоон гарын үсэг ашиглаж эхэлсэн.<br><br>-Цахим бичиг баримтад тоон гарын үсгийг ашиглаж эхэлсэн. | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | -Тоон гарын үсгийн хэрэглээний талаарх гарын авлага боловсруулж байгууллага болон орон нутагт хүргүүлж ажилласан.<br><br>-Багаж баталгаажуулалтын веб хандалтат программ хангамжид туршилтаар тоон гарын үсгийг тохируулсан. Хөгжүүлэлтийн ажил хийгдэж байна.<br><br>-ГЗБГЗЗГ-ын бусад системүүдэд тоон гарын үсгээр нэвтрэх хөгжүүлэлтийн ажил хэрэгжих шатанд явж байна.<br><br>**ХҮРСЭН ҮР ДҮН:** Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох ажлыг хийж байна. Өмнөх жилүүдээс хэрэгжилтийг ахиулж 70%-д хүргэсэн. | | | |
| | | Мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээ, сан байгуулах | Газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим системийг бүрдүүлэх, хөтлөх, тогтвортой үйл ажиллагааг нь хангуулахад шаардагдах зардлын тооцооллыг хийж, системийг нийтийн хэрэглээнд гаргасан. Системийг хөгжүүлэх, мэргэжилтнүүдийг сургах зардлын тооцооллыг хийсэн. Хавсралт файл egazar.gov.mn, mle.mn сайтыг хэрэглээнд гаргасан. Сайтруу нэвтэрч ороход газрын кадастрын нэгдсэн систем, газрын төлбөр, үнэлгээний систем, газрын биржийн систем, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн систем зэрэг мэдээллийн системд холбогдож цахимаар үйлчилгээ авах боломжтой.<br><br>Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам"-ыг боловсруулж, Сангийн сайд, Барилга, хот байгуулалтын Сайдын хамтарсан тушаалаар баталсан. Мөн газрын төлбөр, татварын ногдуулалтыг Газрын төлбөр, татварын системээр ногдуулж Татварын удирлагын нэгдсэн | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | системд илгээх бөгөөд энэхүү системээс иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нэхэмжлэл илгээх, нэхэмжлэлийн дагуу төлөгдсөн төлбөр буцаад дээрх системд бүртгэгддэг байхаар системийн хөгжүүлэлтийг хийсэн.<br><br>Барилга, хот байгуулалтын яам, харьяа байгууллагуудын мэдээллийн санг танилцуулах уулзалтыг 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан.<br><br>Уулзалтаар дараах мэдээллийн сангуудыг танилцуулсан.<br><br>- Орон сууцны нэгдсэн мэдээлийн сан<br><br>- Барилгын хүлэмжийн хийн тооллогын систем<br><br>- Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан<br><br>- Барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн цахим сан.<br><br>Барилга, хот байгуулалт, газрын харилцааны салбарт ашиглагдаж буй цахим мэдээллийн системүүдэд дүн шинжилгээ хийх, тэдгээрийн хоорондын уялдаа холбоо, харилцан хамаарлыг тодорхойлох, өгөгдөл, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх шийдлийг боловсруулж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн А/18 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хуралдааныг 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдөр БХБЯ-ны хурлын танхимд зохион байгуулсан. Ажлын хэсгийн хурал дээр Төрийн нарийн бичгийн даргын өгсөн үүрэг даалгавар, ажлын хэсгийн гишүүдийн саналын дагуу мэдээллийн сангуудыг эрэмбэлж, уялдаа холбоо, | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | харилцан хамаарлыг тодорхойлж, өгөгдөл, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх шийдлийг боловсруулж, Барилга, хот байгуулалтын яамны цахим хуудсаар дамжуулан барилгын салбарын мэдээллийн сангийн ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын талаар санал, танилцуулгыг бэлтгэж 2020 оны 03 дугаар 09-ний өдөр Төрийн нарийн бичгийн дарга, газар, хэлтсийн дарга нарт танилцуулсан. Барилгын салбарын нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн цахим программын хөгжүүлэлтийн ажил системийн үндсэн архитектурыг бүрэн програмчлан дуусгаж гэрээг дүгнэж ажлыг хүлээж авсан. Нэгдсэн мэдээллийн сангийн үндсэн архитектуртай уялдуулан Зураг төсөл магадлалын программыг сайжруулах /серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх/, Норм нормативын программын хөгжүүлэлт, Барилга байгууламжийн захиалагчийн хяналтын программ, Орон сууцны нэгдсэн мэдээллийн сангийн программ, Барилгын хүлэмжийн хийн тооллогын системийн программ, Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн программ зэрэг мэдээллийн сангуудын хоорондын мэдээ, мэдээлэл солилцох боломжийг програмчлалын түвшинд шийдвэрлэх шаардлагын хүрээнд нэмэлт хөгжүүлэлтийг хийж гүйцэтгэнэ. Энэ ажлын хүрээнд Норм, нормативын сангийн 2020 оны төлөвлөгөөний 141, 142-т тусгагдсан “Салбарын ажиллах хүч, мэргэжилтэй ажилтны мэдээллийн сангийн программыг үргэлжлүүлэн боловсруулах” болон “Барилгын салбарын тусгай зөвшөөрөлтэй аж, ахуйн нэгж байгууллага болон барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн цахим мэдээллийн сангийн программ хангамж боловсруулах” ажлын даалгавруудыг 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан, Барилгын | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хөгжлийн төв ТӨААТҮГ-т 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 04/1330 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br><br>“Яамны цахим хуудасны мэдээллийг шинэчлэх, бэлтгэх, оруулах ажлын төлөвлөгөө”-г Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/41 дугаар тушаалаар батлуулсан. Барилга, хот байгуулалтын яамны вэб хуудсаар дамжуулан Салбарын мэдээллийн сангийн цахим хуудсыг шинээр хөгжүүлэх ажлыг “Барилга, хот байгуулалтын яамны вэб хуудаст нэмэлт хөгжүүлэлт” хийх зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар болон ажил гүйцэтгэх гэрээнд оруулсан. “Барилга, хот байгуулалтын яамны вэб хуудаст нэмэлт хөгжүүлэлт” хийх зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг 2020 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. “www.mcud.gov.mn”-т ажлын даалгаврын дагуу нэмэлт хөгжүүлэлт хийх, ашиглалтанд оруулах, системийн боловсруулалт, шинэчлэлт зүгшрүүлэлтийг хийх, түүнийг хүлээлгэж өгөх, захиалагчид сургалт зохион байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан “Содон Солушн” ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр байгуулсан. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн А/18 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн дэд ажлын хэсгийн хурлыг 2020 оны 04 дүгээр сарын 22-ний өдөр зохион байгуулсан. Барилга, хот байгуулалтын яамны цахим хуудас www.mcud.gov.mn-т нэмэлт хөгжүүлэлт хийх ажлын хүрээнд салбарын мэдээллийн сангийн цэс үүсгэх, мэдээллийн сангуудаас судалгаа, статистик мэдээллийг яамны вэб хуудсаар дамжуулан гаргах талаар хэлэлцсэн. Ажлын хэсгийн хүрээнд “Орон сууцны | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдээллийн нэгдсэн сан”-ийн суурь мэдээлэл, программ хангамж, мэдээллийн сангийн ажлын явцын талаар 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан. “Орон сууцны нэгдсэн мэдээллийн сан”-г Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн системтэй холбох, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх, хамтран ажиллах уулзалтыг 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан. “Орон сууцны нэгдсэн мэдээллийн сан”-г хөтлөгч байгууллагуудад 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдөр мэдээллийн сангийн программ хангамж, мэдээлэл сангийн ашиглалт, баяжилтын талаар сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд мэдээллийн сангийн хөтлөгч байгууллага Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газар, Төрийн орон сууцны корпораци ТӨХХК, Нийслэлийн орон сууцны корпораци ХК-ны мэргэжилтнүүд оролцсон. Мэдээллийн санг аймгийн хэмжээнд хариуцан хөтлөх нэгж, албан хаагчийг томилж, Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-тай хамтран батлагдсан журмыг хэрэгжүүлж ажиллах тухай 2020 оны 05 дугаар сарын 19-ний 03/1822 тоот албан бичгийг 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлсэн. Мөн мэдээллийн санг хөтлөх тухай 2020 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн 03/1769 тоот албан бичгийг Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газарт, 03/1768 тоот албан бичгийг Төрийн орон сууцны корпораци ТӨХХК, Нийслэлийн орон сууцны корпораци ХК-д тус тус хүргүүлсэн. 2020 оны 05 дугаар сарын 27-ны өдөр “Орон сууцны нэгдсэн мэдээллийн сан”-ийн программ хангамж, мэдээллийн сангийн суурь мэдээлэл, мэдээллийн сангийн ажлын явцын талаар захиалагч байгууллага Барилга, хот байгуулалтын яам, | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдээллийн санг хариуцагч байгууллага Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ, гүйцэтгэгч байгууллага Тэнхлэг Зууч ХХК-ны төлөөллүүд оролцсон уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтаар нэгдсэн санал, дүгнэлтэд хүрч, гүйцэтгэгч байгууллага нь “Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар” болон “Орон сууцны мэдээллийн сангийн программ хангамж боловсруулах ажлын даалгавар”-ын хүрээнд хийгдсэн ажлын тайлан, захиалагч, хариуцагч байгууллагаас гаргасан саналын дагуу мэдээллийн сангийн нэмэлт хөгжүүлэлт, баяжилтын ажлыг хийж гүйцэтгэхээр болсон. Мэдээллийн сангийн нэмэлт хөгжүүлэлт, баяжилтыг хийж, “Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар” болон “Орон сууцны мэдээллийн сангийн программ хангамж боловсруулах ажлын даалгавар”-ын дагуу дэлгэрэнгүй тайланг гаргаж ирүүлэх тухай 2020.05.29-ний 04/1977 тоот албан бичгийг Тэнлэг Зууч ХХК-д хүргүүлсэн.<br><br>2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 2020/86 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ”-ний I хавсралт цахим хуудас хийх ажлын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэгч байгууллага 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдөр загварыг боловсруулан ирүүлж, Төрийн захиргаа удирдлагын газрын даргад загварын төслийг танилцуулан батлуулсан.<br><br>Төрийн нарийн бичгийн даргаар “Салбарын ажиллах хүч, мэргэжилтний мэдээллийн сан бүрдүүлэх” ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, ажлын даалгаврыг 2020 оны 4 дүгээр сарын 12-нд батлуулсан.<br><br>Салбарын ажиллах хүч, мэргэжилтний мэдээллийн санг бүрдүүлэх чиглэлээр БХТ, БТГ-тай хамтран ажиллаж байна. | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Цаашид мэдээлэл солилцох, салбарын хэмжээнд мэдээллийн нэгдсэн санг өргөжүүлэхийн тулд Засгийн газрын 2020 оны 104 дүгээр тогтоолын дагуу тус яамны бүтцийн нэгжийг шинэчлэн батлуулахдаа Статистик мэдээллийн технологийн хэлтсийг 4 орон тоотойгоор шинээр батлуулсан. Энэхүү бүтэц нь байгуулагдсанаасаа хойш яамны цахим системийн шинэчлэлээс эхлэн салбарын бүх мэдээллийг нэгтгэх, дүн шинжилгээ хийх, сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Цаашид 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үргэлжлүүлэн сайжруулах арга хэмжээг нарийвчлан төлөвлөж тусгасан.<br><br>**ХҮРСЭН ҮР ДҮН:** Салбар байгууллагуудын мэдээлэл солилцохүйл ажиллагаа сайжирч шуурхай байдал хангагдсан. | | | |
| 4 | 4.1.1.10.нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх | Албан хаагчдыг төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалтад хамруулах | Яамны болон харьяа байгууллагуудын төрийн албан хаагчдын 2020 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулж, ТНбД-аар батлуулсан. Энэ хүрээнд яамны албан хаагчдыг Англи хэл, сэтгэл судлалын сургалтад хамруулах асуудлыг ТНбД-ын 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/43 дугаар тушаалаар шийдвэрлүүлж, 2 сар сургалтыг зохион байгуулж 30 албан хаагч анхан, дунд, ахисан түвшний сургалтыг амжилттай дүүргэж сертификат гардуулах үйл ажиллагааг зохион байгуулсан.<br><br>Уг сургалтыг ГЗБГЗЗГ-ын албан хаагчдад зориулж зохион байгуулахаар болсон.<br><br>Онлайнаар туршилтын хэлбэрээр 2020 оны 04 дүгээр сарын 10-наас 05 дугаар сарын 01-нд болсон “Жендэрийн сургагч багш бэлтгэх дунд шатны сургалт”-д ГЗБГЗЗГ, БХТ-өөс тус бүр 2 | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | мэргэжилтэнг оролцуулах ажлыг зохион байгуулсан.<br><br>Сөүлийн их сургуулийн “Дэд бүтцийн төлөвлөлт, бүтээн байгуулалт” магистрын тэтгэлэгт сургалтад БХТ-өөс нэг албан хаагч, Үндэсний хөгжлийн газраас зохион байгуулах “Хөрөнгө оруулагчдаас ирүүлсэн гомдлыг цахим хэлбээр бүртгэх, шийдвэрлэлтэд хяналт тавих” сургалтад 2 албан хаагчдын нэрсийг тус тус хүргүүлсэн.<br><br>Японы “Хүний нөөцийг хөгжүүлэх JDS” тэтгэлэгт хөтөлбөрийн бэлтгэл судалгааны хүрээнд яамны албан хаагчдын албан тушаал, нас, боловсрол зэргээр ангилан жендэрт суурилсан болон хүний нөөцийг хөгжүүлэх тогтолцооны талаарх судалгаа гаргаж, имэйлээр хүргүүлсэн. Түүнчлэн уг хөтөлбөрт салбарын болон яамны албан хаагчдын богино хугацааны сургалтын саналыг е-мэйлээр болон утсаар хүргүүлсэн.<br><br>Удирдлагын академийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 18 албан хаагчийг зайн хэлбэрээр хамруулж, улмаар онлайн хэлбэрээр шалгалтаа өгч тэнцсэн 18 албан хаагчид Удирдлагын академийн захирлын 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/122 дугаар тушаалаар сертификат олгосон бөгөөд сертификатыг 2020.06.04-ний өдөр яамны удирдлагуудаас гардуулан олгосон.<br><br>Төрийн албаны мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 16 албан хаагчийг хамруулж байгаа бөгөөд явцын хичээлүүдийг судалж дууссан улмаар шалгалтаар онлайн хэлбэрээр өгч дууссантай холбоотой сертификат олгогдох ажиллагаа хүлээгдэж байна.<br><br>Удирдлагын академиас ирүүлсэн урилгын дагуу тус яаманд буюу төрийн албанд шинээр | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | томилогдсон Б.Биндэръяа, Б.Энх-Амгалан нарыг төрийн албаны чиглүүлэх сургалтад хамруулсан.<br><br>Мөн 2020.01.11-ний өдөр 2020 оноос шинээр мөрдөгдөж эхэлсэн Татварын багц хуулиуд, түүний онцлог зохицуулалт зэргээр Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч нарыг урьж сургалт зохион байгуулж, албан хаагчдыг оролцуулсан.<br><br>Тус яамны Салбар зөвлөлийн тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн гаргасан судалгаа, дүгнэлтийг үндэслэн 12 албан хаагчид ажилласан жилийн нэмэгдлийг шинэчлэн тогтоосон. Түүнчлэн шинэчлэн батлагдсан Төрийн албаны тухай хуулийн 77 дугаар зүйлд төрийн үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасантай холбоотой тус яамны үйлчилгээний албан тушаалд ажиллаж байгаа 4 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг дээрх тушаалаар хамтатган шийдвэрлүүлсэн.<br><br>Тус яамны эрхэлсэн түшмэлийн албан тушаалд ажиллаж буй 10 албан хаагч, Ахлах түшмэлийн ангилалд ажиллаж буй 28 албан хаагч, Төрийн албаны мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад дэс түшмэлийн ангиллын албан тушаалд ажиллаж байгаа 21 албан хаагч, төрийн албанд шинээр томилогдсон чиглүүлэх сургалтад 1 албан хаагчийг тус тус хамруулж нийт 60 албан хаагчид Удирдлагын академийн харьяа Төрийн албаны сургуулийн захирлын шийдвэрээр сертификат олгогдсон.<br><br>**ХҮРСЭН ҮР ДҮН:** Тайлант хугацаанд Албан хаагчдын 90 хувийг сургалтад хамруулсан. | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Албан хаагчдыг авлигын эсрэг төлөвлөгөөт сургалтад хамруулах | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор тус яамны дотоод бүтцийн нэгжүүдэд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Төрийн албаны тухай, Шилэн дансны тухай болон Авлигын эсрэг хуулиудын талаар мэдээлэл хийж, дээрх зөрчлийн талаар тусгайлан таниулж, протокол үйлдэн АТГ-ат сургалт мэдээлэл, авсан арга хэмжээний талаарх тайланг 2020 оны 04-р сарын 10-ны 03/1297 тоот албан бичгээр хүргүүлсэн. 2020 онд шинэ албан хаагчид зориулж АТГ-аас явуулах төлөвлөгөөт сургалтад яамнаас оролцох 15 хүний судалгааг гаргаж АТГ-ын www.iaac.mn цахим хуудасны Сургалт бүртгэх хэсэгт оруулж баталгаажуулав.<br><br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор яамны дотоод бүтцийн нэгжүүдэд сургалт мэдээлэл өгч протокол үйлдүүлэн АТГ-т мэдээлэл бэлтгэн 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 03/1297 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Тайлант хугацаанд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах хадгалах журмыг хэрэгжүүлэн ажиллаж ямар нэгэн зөрчил дутагдал гаргаагүй.Сургалт мэдээлэл 2 удаа хийсэн. | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Цаг үеийн байдлаас шалтгаалж хүмүүс олноор цуглуулахгүй байдлаар сургалтыг зохион байгуулж 2020 оны ХАСХОМ-ыг шинэчлэн гаргахтай холбоотойгоор яамны дотоод цахим системд/ttps://mcud.able.mn/main.php?p=cHiVbGlj/ Мэдүүлэг гаргагч нарт зориулсан гарын авлага болон ЭБАТ-ын боловсруулсан ЗӨВЛӨМЖИЙГ 2021.01.12-ны өдөр байршуулсан.<br><br>**ХҮРСЭН ҮР ДҮН:** Хуулийн үйлчлэлд хамаарах нийт албан хаагчдыг 100% сургалт мэдээллээр хангаж ажилласан. | | | |
| **Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр** | | | | | | |
| 1 | 4.1.2.1.Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх | Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах | Тус яамнаас Барилгын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Геодези, зураг зүйн тухай хууль, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд заасан тусгай зөвшөөрлийг олгох ажлыг цахим хэлбэрээр зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд үүнтэй холбоотой мэдээлэл, системчлэлийг сайжруулан ажиллаж байна. Түүнчлэн Газрын тухай хууль болон Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд иргэн, хуулийн этгээдэд хүргэх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх талаар анхаарч тодорхой хөрөнгө төсөв гарган ажиллаж байна. Энэ хүрээнд газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим системийг бүрдүүлэх, хөтлөх, тогтвортой үйл ажиллагааг нь хангуулахад шаардагдах зардлын тооцооллыг хийж, системийг нийтийн хэрэглээнд гаргасан. Системийг хөгжүүлэх, мэргэжилтнүүдийг сургах зардлын тооцооллыг хийсэн. Хавсралт файл egazar.gov.mn, mle.mn сайтыг хэрэглээнд гаргасан. Сайтруу нэвтэрч ороход газрын кадастрын нэгдсэн систем, газрын төлбөр, үнэлгээний систем, газрын биржийн | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | систем, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн систем зэрэг мэдээллийн системд холбогдож цахимаар үйлчилгээ авах боломжтой.<br><br>**ХҮРСЭН ҮР ДҮН:** Тус яамны үндсэн чиг үүрэгт хамаарах төрийн үйлчилгээний бүх хэлбэрүүд цахим хэлбэрт шилжсэн. Төрийн үйлчилгээгээ ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлдэг. ТББ-ууд үйл ажиллагааны тайланг улирал бүр авч ХШҮ хийхээс гадна цахим мэдээллийн системийг нь шалгаж мэдээллийг татаж нэгтгэдэг. | | | |
| | | Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээнд холбогдох | Газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим системийг бүрдүүлэх, хөтлөх, тогтвортой үйл ажиллагааг нь хангуулахад шаардагдах зардлын тооцооллыг хийж, системийг нийтийн хэрэглээнд гаргасан. Системийг хөгжүүлэх, мэргэжилтнүүдийг сургах зардлын тооцооллыг хийсэн. Хавсралт файл egazar.gov.mn, mle.mn сайтыг хэрэглээнд гаргасан. Сайтруу нэвтэрч ороход газрын кадастрын нэгдсэн систем, газрын төлбөр, үнэлгээний систем, газрын биржийн систем, газар зохион байгуулалтын төлөвлөлтийн систем зэрэг мэдээллийн системд холбогдож цахимаар үйлчилгээ авах боломжтой.<br><br>Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам"-ыг боловсруулж, Сангийн сайд, Барилга, хот байгуулалтын Сайдын хамтарсан тушаалаар баталсан. Мөн газрын төлбөр, татварын ногдуулалтыг Газрын төлбөр, татварын системээр ногдуулж Татварын удирлагын нэгдсэн системд илгээх бөгөөд энэхүү системээс иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нэхэмжлэл илгээх, нэхэмжлэлийн дагуу төлөгдсөн төлбөр буцаад | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | дээрх системд бүртгэгддэг байхаар системийн хөгжүүлэлтийг хийсэн.<br><br>Барилга, хот байгуулалтын яам, харьяа байгууллагуудын мэдээллийн санг танилцуулах уулзалтыг 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан.<br><br>Уулзалтаар дараах мэдээллийн сангуудыг танилцуулсан.<br><br>- Орон сууцны нэгдсэн мэдээлийн сан<br><br>- Барилгын хүлэмжийн хийн тооллогын систем<br><br>- Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан<br><br>- Барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн цахим сан.<br><br>Барилга, хот байгуулалт, газрын харилцааны салбарт ашиглагдаж буй цахим мэдээллийн системүүдэд дүн шинжилгээ хийх, тэдгээрийн хоорондын уялдаа холбоо, харилцан хамаарлыг тодорхойлох, өгөгдөл, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх шийдлийг боловсруулж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн А/18 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хуралдааныг 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдөр БХБЯ-ны хурлын танхимд зохион байгуулсан. Ажлын хэсгийн хурал дээр Төрийн нарийн бичгийн даргын өгсөн үүрэг даалгавар, ажлын хэсгийн гишүүдийн саналын дагуу мэдээллийн сангуудыг эрэмбэлж, уялдаа холбоо, харилцан хамаарлыг тодорхойлж, өгөгдөл, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх шийдлийг боловсруулж, Барилга, хот | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | байгуулалтын яамны цахим хуудсаар дамжуулан барилгын салбарын мэдээллийн сангийн ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын талаар санал, танилцуулгыг бэлтгэж 2020 оны 03 дугаар 09-ний өдөр Төрийн нарийн бичгийн дарга, газар, хэлтсийн дарга нарт танилцуулсан. Барилгын салбарын нэгдсэн бүртгэл мэдээллийн сангийн цахим программын хөгжүүлэлтийн ажил системийн үндсэн архитектурыг бүрэн програмчлан дуусгаж гэрээг дүгнэж ажлыг хүлээж авсан.<br><br>**ХҮРСЭН ҮР ДҮН:** Сүлжээний хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. | | | |
| 2 | 4.1.2.2.Зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх | Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх<br><br>Төрийн бус байгууллагад шилжүүлсэн төрийн үйлчилгээний үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх | БХБ-ын Сайдын Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх тухай 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 23 дугаар тушаалаар Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны БХБЯ-тай хамтран ажиллах 2020/22 гэрээ, 2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулсан. Энэхүү гэрээний хүрээнд 2020 онд Тусгай зөвшөөрлийн комисс 7 удаа хуралдаж 51 үйлдвэрт Тусгай зөвшөөрөл шинээр олгож, 41 үйлдвэрийн Тусгай зөвшөөрлийг сунгасан ба өнөөдрийн байдлаар нийт 532 тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж үйлдвэрлэл эрхэлж байна.<br><br>Салбарын ажилтныг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгүүлэх гэрээ"-г МБНХ-той, мөн өдрийн 22 дугаар тушаалаар "Архитектор, хот төлөвлөлтийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтын чиг үүргийг хэрэгжүүлэх гэрээ"-г МАЭ-тэй байгуулах асуудлыг шийдвэрлүүлэн зохион байгуулсан. | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Уг сургалтын төлөвлөгөөний төсөлд тусгах санал, зөвлөмжийг яамнаас Төрийн нарийн бичгийн даргын 2020.03.20-ны 03/1033 тоот албан бичгээр МБНХ-нд хүргүүлсэн.<br><br>“Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ болон сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий ТББ-ууд 2020 оны 05 дугаар сарын 05-ны байдлаар мэргэшлийн зэрэг горилох, олгох чиглэлээр сургалт зохион байгуулж, 555 ИТА-ыг хамруулсан.<br><br>Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/71, 2020.10.07-ны А/112 дугаар тушаалаар “Архитектор, инженер, төсөвчний мэргэшсэн, зөвлөх, тэргүүлэх зэрэг горилох,сунгах шалгалтын комиссын бүрэлдэхүүн”-ийг тус тус томилуулсан.<br><br>Сургалт, сургалтын төлөвлөгөөний чанарыг сайжруулахаар ТНБД-ын 2020.3.20-ны 03/1033, 2020.6.2-ны 03/1996 тоот албан бичгээр тус тус санал, чиглэл, зөвлөмж хүргүүлсэн. Үүний үр дүнд сургалт эрхлэгч 8 байгууллагууд мэргэшлийн зэрэг горилох, сунгах сургалтыг салгаж, сургалтын түвшинг ахиулж, хүрээ агуулгыг сайжруулсан ба хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй бүтээгдэхүүн үйлчилгээний талаар сургалтын төлөвлөгөөнд тусгаж, ИТА–дад энэ талын мэдлэг, мэдээлэл өгч ажиллахаар болсон.<br><br>Барилга, хот байгуулалтын яаманд 2020.08.12-ны өдөр болсон “Барилгын салбарын ажилтны мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл”-ийн 2 дах удаагийн хуралдаанаар сургалт эрхлэгч ТББ болон мэргэжлийн байгууллагууд, сургалтын үйл ажиллагаатай газар дээр нь үзэж, сургалтын төлөвлөгөөнд орсон өөрчлөлт, цаашид авах арга | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хэмжээний талаар биечлэн танилцах ажлын хэсэг байгуулж ажиллахаар шийдвэрлэсэн.<br><br>Уг шийдвэрийн дагуу БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020.08.19-ний өдрийн А/95 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг салбарын зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа “Монголын барилгачдын нэгдсэн холбоо” ТББ болон сургалт эрхлэгч байгууллагууд, сургалтын үйл ажиллагаа, орчин, байртай танилцах ажлыг хуваарийн дагуу зохион байгуулж, тайлагнасан. 12 ТББ-ын сургалтын үйл ажиллагаатай танилцсан.<br><br>Уг танилцах ажлын үеэр тодруулсан сургалтын тестийн санг шинэчлэх; Сайдын 2017 оны 200 дугаар тушаалаар баталсан дүрмийг шинэчлэх; мэргэшлийн зэрэгтэй ИТА-ын мэдээллийг тодорхой болгож, цахимжуулах; барилгын талбайн зохион байгуулалтын дүрэм боловсруулж, хэрэгжүүлэх; хөдөлмөр зарцуулалтыг өөрчлөх, тарифт цалингийн хэмжээг нэмэх; зөвлөх үйлчилгээг хувьд гаргаж, аливаа барилга байгууламжийг зөвлөх үйлчилгээтэй барих; Барилгын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах; төсөвчид тайлангаа өгдөг, алдаа гаргасан төсөвчдөд ёс зүйн хариуцлага тооцдог байх; сургалт эрхлэгч, зохион байгуулагч байгууллагын үйл ажиллагааны уялдааг сайжруулах болон бусад ажлуудыг сайжруулах арга хэмжээг авч ажиллахаар болсон.<br><br>2020 онд 85 удаагийн сургалт зохион байгуулагдаж, 1875 мэргэшсэн, зөвлөх инженер, архитектор, төсөвчин, эдийн засагч, тэргүүлэх төсөвчин мэргэшлийн зэрэг шинээр олгох, сунгах ажлыг удирдлага, зохицуулалтаар хангаж ажилласан.<br><br>Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн цахим программын үйл ажиллагаа, Барилгын | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгүүлэх тухай гэрээний хэрэгжилт, Санхүүжилт, Тусгай зөвшөөрлийн урьдчилсан дүгнэлт гаргах ажлын хэсгийн үйл ажиллагаатай 2020 оны 4 дүгээр сарын 17, 24, 27-ны өдрүүдэд "Монголын барилгын үндэсний ассоциаци" ТББ-ын үйл ажиллагаанд дээр дурдсан чиглэлүүдээр хяналт шалгалтыг зохион байгуулж 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн №2020/01 дүгнэлтийг гаргасан.<br><br>"Геодезийн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд болон бусад байгууллагуудад Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжийг ашиглуулах журам", "Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжийн хэрэглээг нэмэгдүүлэх, төрийн захиргааны болон хувийн хэвшлийн байгууллагуудад ашиглуулах журам"-ыг Газрын даргын 2020 оны А/181 дугаар тушаалаар батлагдсан "Кадастрын мэдээллийн нэгдсэн системийг ажиллуулах журам"-д нэгтгэн, энэхүү журмын 11, 12 дахь бүлэг болж батлагдсан.<br><br>"Нэгж талбарын хувийн хэрэг хөтлөх журам"-ын төслийг боловсруулсан.<br><br>**ХҮРСЭН ҮР ДҮН:** Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг ТББ-д шилжүүлсэн бөгөөд гэрээний хэрэгжилтийн гүйцэтгэл болон үйл ажиллагаанд нь бодит үзлэг, ХШҮ хийж гэрээг сунгаж ажиллаж байна. | | | |
| 3 | 4.1.2.7.төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг | Төрийн үйлчилгээний чанар хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх | Төрийн чиг үүргийг шилжүүлсэн байдалд хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилгоор АТГ-тай гэрээ байгуулан ажиллаж байгаа "Жи Би Эм Сошиал ресерч консалтинг" ХХК-ын судалгаа авах талаар ирүүлсэн 01/01 | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах | | албан бичгийн хариуг бэлтгэж нийт 6 судалгааг хавсарган 05/1004 албан бичгээр хүргүүлсэн. Албан бичигт дараах дэлгэрэнгүй судалгааг сүүлийн 3 жилийн байдлаар гаргаж хавсаргасан. Үүнд:<br>1. Төрийн зарим чиг үүргийг бусдаар төлөөлүүлэн гүйцэтгүүлж байгаа дэлгэрэнгүй судалгаа<br>2. Тусгай зөвшөөрөл олгож, тэмдэгтийн хураамж төлүүлсэн талаарх Монголын барилгын үндэсний ассоциацийн /2018 оны 1-р сараас эхлэн/ болон 2015-2018 он хүртэлх БХТ-ийн үйл ажиллагааны судалгаа<br>3. Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооноос олгосон тусгай зөвшөөрлийн 2016-2019 оны судалгаа<br>4. Мэргэшлийн зэрэг олгох, сунгах ажлыг зохион байгуулсан БХТ-ийн үйл ажиллагаа /2015-2017/<br>5. Мэргэшлийн зэрэг олгох, сунгах ажлыг зохион байгуулсан Монголын барилгачдын нэгдсэн холбооны судалгаа /2018-2019/<br>Мэргэшлийн зэрэг олгох, сунгах ажлыг зохион байгуулсан -Монголын архитекторуудын эвлэлийн судалгаа /2018-2019/<br>Барилга, хот байгуулалтын яамны албан ёсны https://mcud.gov.mn/цахим хуудсанд | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 2020.11.20-ны өдрийн байдлаар хөндлөнгийн үнэлгээ хийлгэсэн бөгөөд яамдуудаас 73 оноогоор 4-р байр эзэлсэн байна.<br><br>**ХҮРСЭН ҮР ДҮН:** Үнэлгээ хийлгэх ажил хэвшиж, цаашид анхаарах асуудлыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж байна. | | | |
| **Гурав.Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр** | | | | | | |
| 1 | 4.1.3.2.Төсвийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэл, зарцуулалтын хөндлөнгийн хяналт, хариуцлагыг дээшлүүлэх | Санхүүгийн үйл ажиллагаанд аудитын байгууллагаар аудит хийлгэж, өгсөн зөвлөмжийг мөрдөж биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх | Сайдын багцын санхүүгийн нэгдсэн тайлан, харъяа байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд Үндэсний аудитын газраас гаргасан аудитын зөвлөмж, акт албан шаардлагын хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөг ТНбД-аар батлуулан ажиллаж байна.<br><br>Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний 2019 оны санхүүгийн нэгдсэн тайланд өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг 2020 оны эхний хагас жилийн байдлаар гарган 2020 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн 03/2098 тоот албан бичгээр Үндэсний аудитын газарт тус тус хүргүүлсэн.<br><br>Мөн Үндэсний аудитын газрын 2020 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн “Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт хангуулах” тухай 01/2386 дугаар албан бичигт туссан холбогдох зөвлөмжийн биелэлтийг 2020.06.04-ний 01/2050 тоо албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.<br><br>2019 оны сайдын багцын нэгдсэн тайланд хамрагдсан 8 байгууллагаас 2 төсөвт байгууллага, 2 ТӨҮГ , 3 төсөл санд Үндэсний аудитын газраас аудит хийгдэж, 5 байгууллага “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан. “Хот суурин ус | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл" "Зөрчилтэй" санал дүгнэлт авсан. 2 газрын тайлан сайдын багцын түүвэрт хамрагдан дүгнэлт гаргуулах ба 1 төсөл НҮБ-ээс аудит хийгдсэн.<br><br>Шалгалтаар 147.8 сая төгрөгийн төлбөрийн акт, 804.1 сая төгрөгийн албан шаардлага, 912.2 сая төгрөгийн зөвлөмж, зөрчил илэрсэн.<br><br>Аудитын шалгалтад хамрагдсан газруудын зөвлөмж, акт, албан шаардлагыг нэгтгэн ХШҮДАГ-тай хамтран төлөвлөгөө гаргаж, зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг 03/2549 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>**ХҮРСЭН ҮР ДҮН:** Төсвийн төлөвлөлт, зарцуулалтын үр ашиг сайжирж байна. | | | |
| 2 | 4.1.3.4. Төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах | Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын www.iltod.mn, www.shilendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх | Монгол Улсын төсвийн 2020 оны төсвийн төсөлд санал оруулахтай холбогдуулан нийслэл, 21 аймгийн инженерийн дэд бүтэц, инженерийн бэлтгэл арга хэмжээний чиглэлээрх 66 төсөл арга хэмжээний зардлын шинжилгээний маягт, төсөл арга хэмжээ бүрээр бөглөх 30 асуулгыг боловсруулж, зураг төслийн нүүр, магадлалын дүнэлтийг цаасаар болон файлаар жагсаалт гарган нэгтгэж албажуулан БТГ-т 2019.06.08-ны өдөр хүргүүлсэн.<br><br>- Монгол Улсын төсвийн 2020 оны төсвийн санал боловсруулахтай холбогдуулан нийслэл, 15 аймгийн инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний нийт 46 төсөл арга хэмжээ, инженерийн бэлтгэл арга хэмжээний чиглэлээр нийслэл, 6 аймгийн 20 төсөл арга хэмжээний саналыг авч, зардлын шинжилгээний маягтад төсөл арга хэмжээ тус бүрээр 30 асуулгад бөглөж, зураг төсвийн нүүр, магадлалын дүгнэлтийн | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | файл, шаардагдах материалыг боловсруулж мэдээллийг БТГ-т хүргүүлсэн.<br>**ХҮРСЭН ҮР ДҮН:** Төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангасан байна. | | | |
| 3 | 4.1.3.7. Аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах | Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх | Ийм тохиолдол гараагүй. | Үнэлэх боломжгүй/хугацаа болоогүй. | | |
| **Долоо.Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр** | | | | | | |
| 1 | 4.1.7.1.Төрийн бодлого боловсруулах, хэлэлцэх, батлах зэрэг шийдвэр гаргах бүх шатанд тухайн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагыг татан оролцуулах замаар авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэхэд иргэний нийгмийн оролцоог дэмжих | Шийдвэр гаргах шатанд иргэний нийгмийн оролцоо, хяналтын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх ажлыг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах | Тус яам аливаа бодлогын шийдвэр гаргахдаа Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу иргэд, хуулийн этгээд салбарын ТББ, мэргэжлийн холбоодын оролцоог ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулах зэргээр бодитой хангахын зэрэгцээ, бодлогын баримт бичгийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, иргэдийн мэдэх эрхийг хангах зорилгоор яамны www.mcud.gov.mn сайтад байршуулан ажилладаг.Тухайлбал: Сайдын зөвлөл, Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн бүрэлдэхүүнд Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, Монголын барилгачдын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын баригачдын нэгдсэн холбооны төлөөлөл байдаг.<br>Цаашид хүчин төгөлдөр үйлчилж байгаа салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, үр дагаварыг тооцохоор төлөвлөөд байгаа бөгөөд энэ хүрээнд 2020 онд Барилгын тухай хуулийн хэрэгжилтэд мониторинг хийхээр яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан. Энэ | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | дагуу Барилгын тухай хуульд мониторинг хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2020 оны 06-р сарын 10-нд ТНбД-ын А/78 дугаар тушаалаар батлуулан төлөвлөсний дагуу ажлын хэсэг ажиллаж байна. Ажлын хэсэг үр дүнгээ 11 дүгээр сард танилцуулсан бөгөөд 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тогтсон. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Монголын барилгын нэгдсэн холбоо, Барилгачдын үйлдвэрчний эвлэлээс төлөөлөл оруулсан.<br><br>**ХҮРСЭН ҮР ДҮН:** ТББ-ны оролцоог хангаж ажилласан. | | | |
| 2 | 4.1.7.3.Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх | Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож, нийтэд мэдээлэх | Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж байгаа ч төсвөөс олгож байгаа санхүүжилт байхгүй. Төрийн чиг үүргийг шилжүүлсэн байдалд хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилгоор АТГ-тай гэрээ байгуулан ажиллаж байгаа "Жи Би Эм Сошиал ресерч консалтинг" ХХК-ын судалгаа авах талаар ирүүлсэн 01/01 албан бичгийн хариуг бэлтгэж нийт 6 судалгааг хавсарган 05/1004 албан бичгээр хүргүүлсэн. Албан бичигт дараах дэлгэрэнгүй судалгааг сүүлийн 3 жилийн байдлаар гаргаж хавсаргасан.<br><br>**ХҮРСЭН ҮР ДҮН:** Төрийн зарим үйлчилгээг төрийн бус байгууллагад шилжүүлсэн бөгөөд үйл ажиллагаанд нь хяналт тавьж гэрээг сунгаж ажиллаж байна. | 100% | | |
| | | Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэж байгаа ТББ-ын үйл ажиллагаанд мониторинг хийж, дүнг олон нийтэд мэдээлэх, түүний мөрөөр | Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж байгаа ч төсвөөс олгож байгаа санхүүжилт байхгүй. Төрийн чиг үүргийг шилжүүлсэн байдалд хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилгоор АТГ-тай гэрээ байгуулан ажиллаж байгаа "Жи Би Эм | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | холбогдох арга хэмжээ авах | Сошиал ресерч консалтинг" ХХК-ын судалгаа авах талаар ирүүлсэн 01/01 албан бичгийн хариуг бэлтгэж нийт 6 судалгааг хавсарган 05/1004 албан бичгээр хүргүүлсэн. Албан бичигт дараах дэлгэрэнгүй судалгааг сүүлийн 3 жилийн байдлаар гаргаж хавсаргасан. Хөндлөнгийн үнэлгээ хийсэн тайланг эцэслэн хүлээж аваагүй байна.<br><br>**ХҮРСЭН ҮР ДҮН:** Төрийн зарим үйлчилгээг төрийн бус байгууллагад шилжүүлсэн бөгөөд үйл ажиллагаанд нь хяналт тавьж гэрээг сунгаж ажиллаж байна. | | | |
| 3 | 4.1.7.4.Орон нутгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулан ажиллуулах | Орон нутаг дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон яам, агентлагийн дэргэд авлигаас урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулан ажиллуулах | Хяналтын дэд зөвлөлийг салбарт ажиллаж байсан өндөр настнууд болон салбарын ТББ-уудын төлөөлөлтэйгээр байгуулахаар төлөвлөж байна.<br><br>**ХҮРСЭН ҮР ДҮН:** Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд тавих иргэд олон нийтийн хяналтыг сайжруулахаар ажиллаж байна. 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ. | Үнэлэх боломжгүй/хугацаа болоогүй. | | |
| **Арав. Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр** | | | | | | |
| 1 | 4.1.10.1. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэд, төрийн болон төрийн бус байгууллагуудын | Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах | Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж хүмүүс цуглуулан мэдээлэл, сурталчилгаа, сургалт явуулах боломжгүй байсан хэдий ч яамны цахим хуудсанд авлигын эсрэг үйл ажиллагаа, авлигыг үл тэвчих талаар шаардлагатай баримт бичиг, гарын авлагыг байршуулж ажилласан. Мөн Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчилсан | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх | | самбар, зурагт хуудсыг яамны коридор иргэд хүлээж авах байранд байршуулсан.<br>Мөн яамны цахим мэдээллийн хуудсыг шинэчлэн иргэдэд мэдээллийг ил тод шуурхай хүргэн ажиллаж байна.<br>**ХҮРСЭН ҮР ДҮН:** Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо хяналт сайжирч байна. | | | |
| 2 | 4.1.10.4.Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах | Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх | АТГ-аас яам агентлагийн ЭБАТ-д 2020.12.23-ны өдөр цахимаар зохион байгуулсан сургалтад яамны ЭБАТ оролцож үүний үр дүнд ХАСХОМ гаргах нийт албан хаагчиддаа зөвлөмж хүргүүлж, цахим сургалтыг зохион байгуулж, ХАСХОМ-ыг 2021.02.01-ний дотор хүлээн авч тайланг нэгтгэхээр ажиллаж байна.<br>**ХҮРСЭН ҮР ДҮН:** Яамны ЭБАТ сургалтаа тухай бүрт бие даан явуулж байна. | 100% | | |

**Хоёр. Авлигатай тэмцэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар бусад хууль, тогтоомжид заасныг хэрэгжүүлэх хүрээнд:**

| д/д | Агуулга /холбогдох хууль тогтоомжийн заалт/ | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжилт | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Улсын Их Хурал хэлэлцэгдэх хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөлд төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх боломцоо нөхцөлөөр хангах | Яамны цахим хуудсанд хууль тогтоомжийн төсөл, түүний үзэл баримтлал, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт | https://mcud.gov.mn/forum цахим хаягийн хэлэлцүүлэг хэсэгт дараах хууль тогтоомжид санал авахаар байршуулсан.<br>Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл,<br>Ус хангамж, ариутгах татуургын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхийг | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | /Авлигын эсрэг хуулийн 5.1.1./ | үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийсэн тайланг байршуулж, ирүүлсэн саналыг хэрхэн хүлээж авсан талаарх мэдээллийг байршуулж хэвшинэ. | хуулийн этгээдэд олгох, тэдгээрт хяналт тавих журмын төсөл, Геодези, зураг зүйн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журмын төсөл, Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам"-ын нэмэлт өөрчлөлтийн төсөл, Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хуулийн төслүүдэд санал, шүүмж авахаар 2020 онд байршуулсан.<br><br>**ХҮРСЭН ҮР ДҮН:** Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцсэн, танилцах боломжоор хангагдсан. | | | |
| 2 | ХАСУМ, ХАСХОМ, мэдэгдэл, тайлбарыг хуульд заасны дагуу гаргуулан хяналт тавих, тайлагнах<br><br>/Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль/ | ХАСУМ, ХАСХОМ, мэдэгдэл, тайлбарыг хуульд заасны дагуу гаргуулан хяналт тавих, тайлагнах | Авлигатай тэмцэх хөтөлбөрийн биелэлтийг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж протоколын хамт 2020.01.31-ний өдрийн 03/414 тоот албан бичгээр АТГ хүргүүлсэн. Яамны хэмжээнд нийт 64 албан хаагчаас ХАСХОМ-ыг цахимаар хүлээн авч тайланг АТГ хүргүүлсэн.<br>Яамны авлигын эсрэг үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөөг ТНБД-аар батлуулан ГЗБГЗЗГ, БХТ, ХСУХАТАҮЗЗ, ТОСК-т 03/718 тоот албан бичгээр хүргүүлж мөн яамны цахим хуудсанд байршуулсан.<br>Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн Гадаад хамтын ажиллагаа хариуцсан шинжээчээр Б.Анх-Оргилыг, Бодлого төлөвлөлтийн газрын Салбарын норм, нормативын бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээчийн орон тоонд Б.Гандолгорыг шилжүүлэн томилохоор, НААБХЗГ-ын усны барилга, байгууламжийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтний сул орон тоонд М.Жаргалсайханыг түр, Гадаад хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтний сул орон тоонд Б. Энх-Амгаланг, Хот байгуулалт газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтний орон тоонд | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Байжаны Нурбекийг томилохоор тус тус нэр дэвшүүлсэн бөгөөд эдгээр албан хаагчдын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар АТГ-т хүргүүлж хариуг ирмэгц ТЗУГ-ын хүний нөөц хариуцсан ахлам мэргэжилтэнд хувилж өгсөн. Мөн томилогдсон Х.Ерхулан, Б.Анх-Оргил нарын ХАСХОМ-ыг хугацаанд нь авч хянан баталгаажуулсан.<br>Төрийн чиг үүргийг шилжүүлсэн байдалд хөндлөнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилгоор АТГ-тай гэрээ байгуулан ажиллаж байгаа “Жи Би Эм Сошиал ресерч консалтинг” ХХК-ын судалгаа авах талаар ирүүлсэн 01/01 албан бичгийн хариуг бэлтгэж нийт 6 судалгааг хавсарган 05/1004 албан бичгээр хүргүүлсэн. Албан бичигт дараах дэлгэрэнгүй судалгааг сүүлийн 3 жилийн байдлаар гаргаж хавсаргасан. Үүнд:<br>Төрийн зарим чиг үүргийг бусдаар төлөөлүүлэн гүйцэтгүүлж байгаа дэлгэрэнгүй судалгаа<br>Тусгай зөвшөөрөл олгож, тэмдэгтийн хураамж төлүүлсэн талаарх Монголын барилгын үндэсний ассоциацын /2018 оны 1-р сараас эхлэн/ болон 2015-2018 он хүртэлх БХТ-ийн үйл ажиллагааны судалгаа<br>Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооноос олгосон тусгай зөвшөөрлийн 2016-2019 оны судалгаа<br>Мэргэшлийн зэрэг олгох, сунгах ажлыг зохион байгуулсан БХТ-ийн үйл ажиллагаа /2015-2017/<br>Мэргэшлийн зэрэг олгох, сунгах ажлыг зохион байгуулсан Монголын барилгачдын нэгдсэн холбооны судалгаа /2018-2019/<br>Мэргэшлийн зэрэг олгох, сунгах ажлыг зохион байгуулсан -Монголын архитекторуудын эвлэлийн судалгаа /2018-2019/<br>Шинээр болон шилжин томилогдсон Ням-Очир, Э.Оюунчимэг, С.Оюунжаргал,Б.Нурбек, Б.Гандолгор, Б.Энх-Амгалан нарын ХАСХОМ-ыг хугацаанд нь авч хянан баталгаажуулсан. | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Мөн "Хариуцлага тооцож, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай" АТГ-аас ирүүлсэн 01/3929 албан бичгийн мөрөөр тус яамны Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Б.Алтайбаатар, Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн зохицуулагч Т.Болорчулуун, Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч О.Энхтуяа нарт Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулж, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээг тооцуулахаар ТНБД-ын тушаалын төслийг боловсруулж, арга хэмжээг тооцуулав. Дээрх албан тушаалтанд арга хэмжээ авсан талаар болон хуулийн хэрэгжилтийг хангах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай 03/1297 албан бичгийг АТГ-т хүргүүлсэн.<br>2020 онд шинэ албан хаагчид зориулж АТГ-аас явуулах төлөвлөгөөт сургалтад яамнаас оролцох 15 хүний судалгааг гаргаж АТГ-ын www.iaac.mn цахим хуудасны Сургалт бүртгэх хэсэгт оруулж баталгаажуулав.<br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор яамны дотоод бүтцийн нэгжүүдэд сургалт мэдээлэл өгч протокол үйлдүүлэн АТГ-т мэдээлэл бэлтгэн 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 03/1297 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>Тайлант хугацаанд Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах хадгалах журмыг хэрэгжүүлэн ажиллаж ямар нэгэн зөрчил дутагдал гаргаагүй.Сургалт мэдээлэл 2 удаа хийсэн.<br>3 дугаар улирлын байдлаар шинээр томилогдсон 14 албан хаагчийн ХАСХОМ, 3 албан хаагчийн хөрөнгө орлогод их хэмжээний өөрчлөлт орсон тул хуулийн хугацаанд ХАСХОМ-ыг хүлээн авч, хянаж бүртгэв. Мөн улиралд түмилогдохоор нэр дэвшсэн 19 хүний ХАСУМ-ыг хүлээн авч холбогдох материалыг хавсарган АТГ-т хянуулахаар хүргүүлсэн.<br>Яамны цахим хуудсанд 2020 онд шинээр томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ хянасан АТГ-ын албан бичгийг байршуулсан.<br>Засгийн газрын 2020 оны 104 дүгээр тогтоолын дагуу тус яамны бүтцийн нэгжийг шинэчлэн батлаж нийт хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн баталсан бөгөөд энэ дагуу албан тушаалын чиг үүрэг нь солигдсон болон шинээр томилогдсон нийт 55 албан хаагчдын ХАСХУМ-ыг хянуулахаар АТГ-д хүргүүлж, томилогдсон 55 албан хаагчийн ХАСХОМ-ыг хуулийн хугацаанд нь бүрэн гаргуулж хянаж баталгаажуулсан.<br>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан 196 мэдэгдлийг хүлээн авч бүртгэв.<br><br>**ХҮРСЭН ҮР ДҮН:** Хууль тогтоомжид заасан шаардлагад нийцсэн. | | | |
| 3 | Авлигатай тэмцэх талаар сургалт, сурталчилгаа явуулах, хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв | БХБЯ болон тухайн салбарын чиг үүргийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан болон хууль, тогтоомжид заасанаар эрх шилжүүлэн авсан, эрхийг | Авлигатай тэмцэх хөтөлбөрийн биелэлтийг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж протоколын хамт 2020.01.31-ний өдрийн 03/414 тоот албан бичгээр АТГ хүргүүлсэн.<br><br>Яамны авлигын эсрэг үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөөг ТНбД-аар батлуулан ГЗБГЗЗГ, БХТ, | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | гаргуулах, бүртгэх, хянах, зөвлөгөө өгөх | төлөөлөн хэрэгжүүлдэг байгууллагуудтай хамтран авлигын эсрэг болон сонирхлын зөрчлийн эсрэг хууль тогтоомжийг сурталчилах арга хэмжээ зохион байгуулах | ХСУХАТАҮЗЗ, ТОСК-т 03/718 тоот албан бичгээр хүргүүлж мөн яамны цахим хуудсанд байршуулсан.<br><br>2020 онд шинэ албан хаагчид зориулж АТГ-аас явуулах төлөвлөгөөт сургалтад яамнаас оролцох 15 хүний судалгааг гаргаж АТГ-ын www.iaac.mn цахим хуудасны Сургалт бүртгэх хэсэгт оруулж баталгаажуулав.<br><br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор яамны дотоод бүтцийн нэгжүүдэд сургалт мэдээлэл өгч протокол үйлдүүлэн АТГ-т мэдээлэл бэлтгэн 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 03/1297 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br><br>Цаг үеийн байдлаас шалтгаалж хүмүүс олноор цуглуулахгүй байдлаар сургалтыг зохион байгуулж 2020 оны ХАСХОМ-ыг шинэчлэн гаргахтай холбоотойгоор яамны дотоод цахим системд/ttps://mcud.able.mn/main.php?p=cHiVbGlj/ Мэдүүлэг гаргагч нарт зориулсан гарын авлага болон ЭБАТ-ын боловсруулсан ЗӨВЛӨМЖИЙГ 2021.01.12-ны өдөр байршуулсан.<br><br>**ХҮРСЭН ҮР ДҮН:** Хууль тогтоомжийг сурталчилан таниулах, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх нэгдсэн арга хэмжээг хамтран зохион байгуулсан байна. | | | |
| 4 | Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол оруулж хэвших | Цахим системд мэдээлэл оруулах албан хаагчдыг тодорхойлж, үйл ажиллагаа нь | Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын дагуу календарчилсан төлөвлөгөө батлуулан харъяа байгууллагуудын шилэн дансны мэдээллийн тайланг улирал бүр гаргуулан авч Засгийн газрын 2016 оны 29 | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | /Шилэн дансны тухай хуулийн 6,7 дугаар зүйл/ | тогтмолжуулж, хяналтыг сайжруулах | дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8.2 дахь хэсэгт заасны дагуу Барилга, хот байгуулалтын сайдын багцын 2019 оны 4 дүгээр улирлын тайланг 2020 оны 01 сарын 24-ны өдрийн 09/300 тоот, 2020 оны 1 дүгээр улирлын тайланг 2020 оны 04 сарын 24-ны өдрийн 09/1500 тоот албан бичгээр Сангийн яамны Төсвийн хяналт эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлсэн.<br>Шилэн дансны мэдээлэлд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан **196 мэдэгдлийг** хүлээн авч бүртгэв.<br>**ХҮРСЭН ҮР ДҮН**: Хууль тогтоомжид нийцсэн. | | | |
| 5 | Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх | 16.6. АТГ-ын даргын 2012 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Албан тушаал-тан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг хэрэгжүүлж ажиллах | “Хариуцлага тооцож, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай” АТГ-аас ирүүлсэн 01/3929 албан бичгийн мөрөөр тус яамны Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Б.Алтайбаатар, Төв цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслийн зохицуулагч Т.Болорчулуун, Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч О.Энхтуяа нарт Захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсох ажиллагаа явуулж, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээг тооцуулахаар ТНбД-ын тушаалын төслийг боловсруулж, арга хэмжээг тооцуулав. Дээрх албан тушаалтанд арга хэмжээ авсан талаар болон хуулийн хэрэгжилтийг хангах талаар авч хэрэгжүүлсэн | 100% | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | арга хэмжээний тухай 03/1297 албан бичгийг АТГ-т хүргүүлсэн.<br>Албан тушаалтанд арга хэмжээ авсан талаарх шийдвэрийг яамны цахим хуудсанд тодорхой хугацаагаар байршуулсан.<br>**ХҮРСЭН ҮР ДҮН:** Зөвлөмж чиглэлийг танилцуулж, хэрэгжилтийг зохион байгуулсан. | | | |

ТАНИЛЦСАН:ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА С.МАГНАЙСҮРЭН

ХЯНАСАН:ТЗУГ-ЫН ДАРГА Д.БАЯРСАЙХАН

НЭГТГЭСЭН: ХШҮДАГ-ЫН АХЛАХ ШИНЖЭЭЧ Д.МОНГОЛЖИНГОО